## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах эм, эмнэлгийн хэрэгсэл талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа /ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

| **ТОӨЗ-ны холбогдох заалт** | **А. Ерөнхий зүйл** |
|---|---|
| **ТОӨЗ 1.1** | Захиалагч нь: Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар |
| **ТОӨЗ 1.1** | Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Дундговь аймгийн сумын эрүүл мэндийн төвд шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах Тендер шалгаруулалтын дугаар: ДУГАЭМГ/202202001 |

**ТӨЗ 1.2**

Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

| **Багцын дугаар** | **Багцын нэр** |
|---|---|
| Багц 1 | Нянгийн эсрэг бэлдмэл /антибиотикууд/ м |
| Багц 2 | Зүрх судасны эмүүд |
| Багц 3 | Цусны даралт бууруулах болон шээс хөөх эмүүд |
| Багц 4 | Амин дэм эрдэс бодисууд |
| Багц 5 | Дааврын болон спазмолитик эмүүд |
| Багц 6 | Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх нүдний өвчний ба харшлын эсрэг эмүүд |
| Багц 7 | Үрэвслийн эсрэг өвчин намдаах эмүүд |
| Багц 8 | Ходоод гэдэс элэг цөсний эмүүд |
| Багц 9 | Төрөл бүрийн өвчинд хэрэглэдэг хатуу эмийн хэлбэрүүд |
| Багц 10 | Төрөл бүрийн өвчинд хэрэглэдэг шингэн эмийн хэлбэрүүд |
| Багц 11 | Хорт мансууруулах ,сэтгэцэд нөлөөт болон уналт таталтын эсрэг эмүүд |
| Багц 12 | Бусад эмийн хэлбэрүүд |
| Багц 13 | Судсаар сэлбэх тарилгын шингэнүүд |
| Багц 14 | Нэг удаагийн тариур |
| Багц 15 | Мэс заслын эмнэлгийн хэрэгсэл |
| Багц 16 | Ороох боох болон нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл |
| Багц 17 | Бусад эмнэлгийн хэрэгсэл |
| Багц 18 | Халдваргүйжүүлэх болон үжлийн эсрэг бодис |
| Багц 19 | Эх барихын нэг удаагийн хэрэгсэл |
| Багц 20 | Цус цусан бүтээгдэхүүний бодис |
| Багц 21 | Тан эм |
| Багц 22 | Эмнэлгийн хэрэгсэл /УАУНЭ/ |

| | |
|---|---|
| **ТОӨЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: **Улсын төсөв** |
| | **Б. Тендерийн баримт бичиг** |
| **ТОӨЗ 8.1** | Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:<br>**Tender.gov.mn**<br>**Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар утас: 70593667, 99056522** |
| **ТОӨЗ 8.1** | Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын **5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авна.** |
| | **В. Тендер бэлтгэх** |
| **ТОӨЗ 11.1** | Тендерийн хэл нь Монгол хэл дээр байна. |
| **ТОӨЗ 12.1 (а) – (è)** | 12.1 (а) - (è)-д заасан баримт бичгээс гадна дараах материалыг нэмж бүрдүүлнэ.<br>Тендерт оролцогч нь үндсэн үйлдвэрлэгч биш бол үндсэн үйлдвэрлэгчийн бараа нь чанарын стандартыг хангасан бөгөөд захиалсан тооны барааг үйлдвэрлэх чадвартайг баталсан баталгааг харуулах шаардлагатай. “Үндсэн үйлдвэрлэгч“-гэж эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэж тодорхой тунгийн дагуу хэлбэржүүлэх, савлах, хаяглах болон чанарын шинжилгээ хийдэг үйлдвэрлэгчийг хэлнэ. Тендерт оролцогч нь үйлдвэрлэгчийн орны зохицуулагч эрх бүхий этгээдээс эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх эрхийг баталгаажуулсан гэрчилгээг хавсаргасан байна. |
| **ТОӨЗ 13** | Тендер хариуцсан ажилтны тухайн компанид орсон тушаал, нийгмийн даатгал төлсөн баримт ,эм барих эрхийн лицензийн хуулбарыг ирүүлэх. |
| **ТОӨЗ 14.1** | Хувилбарт тендер ирүүлэхийг **“зөвшөөрөхгүй”** |
| **ТОӨЗ 15.5** | Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар: “Incoterms 2000” |
| **ТОӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)** | Бараа хүргэгдэх газар: **Дундговь аймаг Эрүүл мэндийн газар** |
| **ТОӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)** | “Бараа хүргэгдэх эцсийн цэг”: **Дундговь аймгийн Эрүүл мэндийн газрын агуулах** |
| **ТОӨЗ 15.9 (б) (1)** | Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТОӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан CIP үнээс гадна дараах үнээр санал болгож болно. Үүнд: |
| **ТОӨЗ 15.10** | Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад **“тохируулахгүй тогтмол байна.”** |
| **ТОӨЗ 16.1** | Тендерийн валют: **Төгрөг байна.** |
| **ТОӨЗ 18.1** | Тусгай зөвшөөрөл: **“Импортын лиценз”, “Үйлдвэрлэгчтэй хийсэн гэрээ** |

| | |
|---|---|
| (а) | **,Бусад шаардлагатай тусгай зөвшөөрөл** |
| **ТӨЗ 18.1 (б)** | Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 1 жил буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,** |
| **ТӨЗ 18.1 (г)** | Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жилд гүйцэтгэсэн ижил төстэй нийлүүлэлтийн нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлнэ.**<br>**2 жилд гүйцэтгэсэн томоохон ижил төстэй нийлүүлэлтийн гэрээ, бараа хүлээлцсэн актыг ирүүлнэ.** |
| **ТӨЗ 18.1 (д)** | Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: **“шаардлагатай”**<br>• ***Эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлсний дараах хугацаанд, чанарын шаардлага хангаагүй барааг, эргүүлэн шаардлага хангасан бараагаар солих.***<br>• ***Барааны савлалтын алдаанаас гарсан хохирлыг нөхөн барагдуулах. (серийн дугаар, савлагчийн дугаар, бусад баримттай тулгах).***<br>• ***Эм эмнэлэгийн хэрэгслийн хэрэглэх хүчинтэй хугацаа 1 жилээс дээш байх*** |
| **ТӨЗ 18.2 (а)** | Борлуулалтын хэмжээ: **2021 оны** жилийн дундаж борлуулалтын орлого нь оролцож буй нийт багцын төсөвт өртөгийн **30 хувиас багагүй байна.** |
| **ТӨЗ 18.2 (б)** | Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: **2 жил** |
| **ТӨЗ 18.2 (в)** | Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: **шаардлагагүй** |
| **ТӨЗ 18.2 (г)** | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Ирүүлсэн багцын нийлбэр үнийн саналын 30 хувьтай тэнцэх дүнгээс багагүй байна** . Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээг доорх 2-ын аль нэгээр тодорхойлон ирүүлнэ.<br>1. Байгууллагын харилцагч банкинд дах дансны үлдэгдэл /тендер ирүүлэхээс өмнөх 10 хоногийн дотор авсан тодорхойлолтыг хүчинтэйд тооцно/<br>2. Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /арилжааны банкны судалж үзээд шаардлага хангасан тохиолдолд зээл олгоно гэсэн тодоройлолтыг хүчингүйд тооцно/ |
| **ТӨЗ 18.2 (д)** | Ашигтай ажилласан байх жилийн тоо: 2 **жил** |
| **ТӨЗ 18.2** | Тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт: |

| | |
|---|---|
| | Дараах баримт бичгүүдийг тендерт заавал хавсаргана.<br><br>Тендер нь шалгарсан тохиолдолд тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг үнэлэхэд дараах нөхцөл байдлыг нотлох баримт бичиг шаардагдана:<br><br>(i) Хэрэв тендерт оролцогч нь өөрийн үйлдвэрлэсэн барааг нийлүүлж буй бол:<br><br>(а) тендерийн баримт бичигт заагдсан эм, эмнэлгийн хэрэгслийг 2-оос доошгүй жил, ижил төрлийн барааг 3-аас доошгүй жил үйлдвэрлэж, борлуулсныг;<br><br>(б) ДЭМБ-ын GMP-ийн сертификаттай эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсад худалдаанд гаргах эрхийг тухайн орны зохицуулах эрх бүхий этгээдээс авсан, эсхүл PIC-ийн гишүүн орны эрх бүхий этгээдээр баталгаажсан бөгөөд тендер ирүүлэх хүртэлх сүүлийн 2 жилд чанарын стандартын шалгалт хийгдсэнийг;<br><br>(ii) Хэрэв тендерт оролцогч нь нийлүүлж буй бараагаа өөрөө үйлдвэрлээгүй бол,<br><br>(а) Тендерт оролцогч нь барааг нийлүүлэх зөвшөөрлийг үйлдвэрлэгч эсхүл гэрээт борлуулалгчаас албан ѐсоор авсан буюу Монгол улсад тухайн барааг нийлүүлэх шалгууруудыг хангасныг;<br><br>(б) Шаардлагатай бол GDP (Good Distribution Practice)-ийн сертификат авсныг<br><br>В<br><br>Тендерт оролцогч нь дараах нэмэлт мэдээллийг хавсаргана:<br><br>**(а) Үйлдвэрлэлийн хүчин чадлын мэдээлэл;**<br><br>**(б) Тендерт оролцогчийн үйлдвэрлэсэн эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт гэрчилгээний хамт, Тусгай зөвшөөрлийн дугаар, огноо**<br><br>**(в) ДЭМБ-ын журмын дагуу барааны нэр төрөл тус бүрд авсан эм, эмнэлгийн хэрэгслийн сертификат.**<br><br>**г)Татварын өр төлбөртэй эсэх тодорхойлолт 2022 оны 03 сарын байдлаар /QR кодтойгоор цахим системээс авах/**<br><br>**д) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт эх хувиар 2022 оны 3 сарын байдлаар**<br><br>**е) Харилцагч банкинд өр төлбөртэй эсэх, хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх тодорхойлолт эх хувиар 2022 оны 3 сарын байдлаар**<br><br>**ж) Улсын бүртгэлийн гэрчилгээ /Эхээс нь өнгөтөөр хуулбарлах/**<br><br>**з) Эрүүл мэндийн яамнаас олгосон Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан борлуулах тухай тусгай зөвшөөрлийн хуулбарыг ирүүлэх /Эхээс нь өнгөтөөр хуулбарлах/**<br><br>(и) Шаардлагатай бүтээгдэхүүнээс дээж ирүүлэх, Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар 208 тоот хаягаар<br><br>(й) Гадаадаас импортлож буй эмийн ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг орчуулгын товчоогоор монгол хэлрүү хөрвүүлж батлуулсан байх. |

| | |
|---|---|
| **ТӨЗ 18.4** | Дотоодын давуу эрхийн зөрүү: **багц 4,13 дээр тооцно** |
| **ТӨЗ 19.1.(б)** | Барааг тасралтгүй горимын дагуу ашиглах, эсхүл ажиллуулахаар тооцоолж буй хугацааны үе (энэ хугацаанд шаардагдах сэлбэг хэрэгслийг тооцоолох зорилготой) **1 жилээс дээш** |
| **ТӨЗ 20.1** | Тендер нээснээс хойш **30** хоногийн туршид хүчинтэй байна. |
| **ТӨЗ 21** | Тендерийн баталгааны үнийн дүн: **Оролцох нийт багцуудад санал болгож буй үнийн дүнгийн нийлбэрийн 1%-тай тэнцэх тендерийн баталгааг баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар гаргуулна.**<br>Хүчинтэй байх хугацаа: **2022 оны 06 сар 22 өдөр** |
| **ТӨЗ 21.1** | Тендерт оролцогч гэрээний үнийн дүнгийн **5 хувьтай тэнцэх гүйцэтгэлийн** баталгаа гаргаж өгнө. |
| | **Г. Тендер ирүүлэх** |
| **ТӨЗ 23.3 (б)** | Тендер хүлээн авах захиалагчийн хаяг:<br>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/ хаягаар өөрийн ААН-ийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50 000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны е-меркантын системийг ашиглан төлнө. |
| **ТӨЗ 24.1** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.<br>Огноо: **2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр**<br>Цаг: **14 цаг 00 минут** |
| | **Д. Тендерийг нээх, үнэлэх** |
| **ТӨЗ 28.1** | Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:<br>Байшин, гудамжны нэр: **Буяннэмэхийн өргөн чөлөө, 60-р байр Эрүүл мэндийн газар**<br>Давхар болон өрөөний дугаар: **1 давхар 105 òîîò өрөө**<br>Аймаг, хот: **Дундговь аймаг, Сайнцагаан сум**<br>Улс: **“Монгол Улс”**<br>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:<br>Огноо: **2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр**<br>Цаг: **14 цаг 30 минут** |
| | **Е. Гэрээ байгуулах эрх олгох** |

| | |
|---|---|
| **ТОӨЗ 40.1** | Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: **гэрээ байгуулах үед шийдвэрлэнэ.**<br><br>Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: **гэрээ байгуулах үед шийдвэрлэнэ.** |